



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/575

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.4, 23.1.9 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II Хуралдааны аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай II/04 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV Хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөвт батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/574 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1 Юнескогийн хүн төрөлхтний соёлын биет бус өвд Монгол Улсаа төлөөлөн бүртгэгдсэн Хөхүүрийн айрагны соёлыг тээн авч ирж, түгээн дэлгэрүүлж буй малчид, адуучдыг хамруулан зохион байгуулагддаг “Айраг фестиваль” аялал жуулчлалын эвентийн бэлтгэл ажлын хүрээнд сурталчилгааны туг, хулдаасан хэвлэл, тэмцээн уралдааны медаль хийлгэхэд шаардагдах зардал 9,075,600 (есөн сая далан таван мянга зургаан зуу) төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2.Хасвралтад тусгагдсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй гэрээ байгуулж, хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллан, хүлээж авахыг Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба (Г.Алтанцэцэг)-д үүрэг болгосугай.

2.Шаардагдах зардлыг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний “Аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулах” төсөл арга хэмжээний зардлаас зарцуулахыг сангийн нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



0324010770

Аймгийн Засаг даргын 2024 оны 8 дугаар сарын 06-ны/ний өдрийн 197 дүгээр/дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

**СУРТАЛЧИЛГААНЫ ТУГ, ХУЛДААСАН ХЭВЛЭЛ, МЕДАЛЬ
ХИЙЛГЭХ ТӨСВИЙН ЗАДАРГАА**

№	Зардлын нэр	Гүйцэтгэгчийн нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Сурталчилгааны туг	С.Бямбацэрэн	16ш	200,000	3,200,000
2	Сурталчилгааны хулдаасан хэвлэл	В.Чимэдбаатар	141,3 м.кв	12,000	1,695,600
3	Хулдаасан хэвлэлийн бөгж	В.Чимэдбаатар	500	500	250,000
4	Медаль	"Титэм дизайн" ХХК	140	24,500	3,430,000
5	Эх бэлтгэл	"Титэм дизайн" ХХК	10	50,000	500,000
Нийт дүн					9,075,600